



Өдөр бүр уулзах үндэсний
шилдэг компани

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020



“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2020

Фото зургийг Төгөл
Хөвсгөл

КОМПАНИЙ ЕРӨНХИЙ ТОЙМ

- 6 Мэндчилгээ
- 8 Төлөөлөн удирдах зөвлөл
- 10 Компанийн 2020 оны зорилго, зорилтууд
- 12 Түүхэн товчоо
- 14 Цар тахал ба хямралын менежмент
- 16 Онцлох үйл явдлууд
- 20 Хэрэглэгчийн үйлчилгээний чанар

ХҮНИЙ НӨӨЦ ГАДААД ХАРИЛЦААНЫ АЖЛЫН ХҮРЭЭНД

- 22 Хүний нөөц, хөдөлмөрийн харилцааны талаар

ШУУДАНГИЙН ТЕХНОЛОГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

- 26 Улс хоорондын шуудангийн сүлжээний ашиглалт тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах талаар
- 28 Улс хоорондын шуудангийн хэвийн үйл ажиллагааг хангах
- 30 Дотоод шуудангийн үйл ажиллагааны талаар

ТЭЭВЭР ЗУУЧ, ЛОГИСТИКИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

- 32 Хил дамнасан и-худалдаа буюу транзит шуудангийн үйлчилгээ
- 32 Хот доторх хүргэлт буюу гараас-гарт хүргэлтийн үйлчилгээ
- 33 Хот хоорондын ачаа тээврийн үйлчилгээ

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 34 Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

“ЦАХИМ ШИЛЖИЛТ” АЖЛЫН ХҮРЭЭНД

- 36 Программ хангамж хөгжүүлэлт, хэвийн найдвартай ажиллагааг хангах

МАРК ҮНЭТ ЦААСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

- 38 Марк үйлдвэрлэл
- 40 Дугтуй, үнэт цаасны үйлдвэрлэл

САНХҮҮ ЭДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

51 АУДИТЫН ТАЙЛАН

58 САЛБАРЫН ХАЯГ БАЙРШИЛ



Хүннү гүрнээс эхлэлтэй Өртөө шуудангийн буурал түүхтэй “Монгол шуудан” ХК-ийн баялаг түүхийг бүтээхэд өөрийн мэдлэг чадвар, хүч хөдөлмөрөө зориулсан үе үеийн ахмад буурлууд, Монгол орны өнцөг булан бүрт ажиллаж, амьдарч буй нийт шууданчид болон хамтран ажилладаг байгууллага, харилцагч, үйлчлүүлэгч, хувьцаа эзэмшигч нартаа,

Монгол Улсад орчин цагийн харилцаа холбоо, шуудан, мэдээлэл технологийн салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн халуун мэндийг дэвшүүлж, түүхэн энэ цаг үеийн хариуцлагатай мөчид бидэнтэй хамтран ажиллаж байгаад талархал илэрхийлье!

2020 онд Дэлхий нийтээр цар тахалтай тэмцсэн, хүндрэл бэрхшээлийг хохирол багатайгаар даван туулахад чиглэсэн, томоохон сорилтын жил байлаа. Манай компанийн хувьд бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллаж, хүнд бэрх цагтай нүүр тулж шуудангийн үйл ажиллагааг нэг өдрөөр байтугай нэг цагаар ч таслалгүй явууллаа. Хатуу хөл хорионы дэглэмийн үед шуудангийн үйлчилгээний ачаалал эрс нэмэгдэж, уртасгасан цагаар ажиллаж, бүх нийтийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй, хариуцлагатай биелүүлж энэхүү том сорилтыг хамт олныхоо хүчин чармайлтаар амжилттай даван туулж байна. Байгууллагын стратеги бодлого, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ажлыг уян хатан, хөрвөх чадвар сайтай байх тал дээр анхаарч тасралтгүй сайжруулж, хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг цаг тухай бүрт нь хангаж чадсандаа баяртай байна.

Бид цаашдаа нэгэн зууны бахдам түүхийг үргэлжлүүлэн шилдэг боловсон хүчин, ухаалаг үйлчилгээ, тохилог орчинг бүрдүүлэн, аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалтай хөл нийлүүлэн цахим шилжилтийг түүчээлэн хийж дэлхийд тэргүүлсэн дижитал шуудан, хүргэлтийн компани болох зорилго тавин ажиллах болно.

Энэхүү зорилгыг биелүүлэхэд хичээл зүтгэлээ зориулан ажилладаг нийт шууданчид болон бидэнд итгэл хүлээлгэн үйлчлүүлдэг нийт харилцагчдадаа халуун талархал илэрхийлье.

Та бидний зорилго нэг байж, ажил үйлс өөдрөг байхын ерөөлийг өргөж 2020 онд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж байгааг хүлээн авна уу.

Эрхэм та манай компанийн 2020 оны жилийн тайланг хүлээн авна уу.

Хүндэтгэсэн:

Гүйцэтгэх захирал
БАДАМРАЙН АНХБААТАР



Д.НАРАНГЭРЭЛ

ТУЗ-ийн дарга

ТӨБЗГ-ын ТӨБХХ-ийн дарга



Д.ДЭЛГЭРМАА

ТУЗ-ийн гишүүн

ТӨБЗГ-ын ХЗА-ны дарга



С.МӨНГӨНЦЭЦЭГ

ТУЗ-ийн гишүүн

СЯ-ны ТЗУГ-ын СЗБХ-ийн дарга



Ч.ДОНДОГМАА

ТУЗ-ийн гишүүн

ЗГХЭГ-ын ахлах референт



Ч.ГАНХУЯГ

ТУЗ-ийн гишүүн

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн
гүйцэтгэх захирал



Г.ТЭЛМЭН

ТУЗ-ийн гишүүн

“Ард Кредит ББСБ” ХК-ийн
Гүйцэтгэх захирал



В.ГАНЗОРИГ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

“Бат солюшн партнерс” ХХК-ийн
ТУЗ-ийн дарга



Б.ГАНБААТАР

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Монголын өмгөөлөгчдийн
холбооны ерөнхийлөгч



Д.БАЛДОРЖ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Маркетингийн Холбооны УЗ-ийн гишүүн



Компанийн 2020 зорилтууд

Фото зургийг Түшиг
Улаанбаатар



КОМПАНИЙН 2020 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Стратеги

Улс хоорондын

ШУУДАНГИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ



Санхүүгийн

ҮЙЛЧИЛГЭЭГ ЭХЛҮҮЛЭХ, НЭР ТӨРЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ



Сүлжээ ашиглалтыг

САЙЖРУУЛАХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ



МОНГОЛ ШУУДАНГИЙН ТҮҮХ

1921-2020 он



Шуудан харилцаа нь Хүннү гүрний үеэс, он цагийг илүү наашлуулбал их эзэн Чингис хааны хүү Өгөдэй хааны дөрвөн сайн үйлийн нэг болох сайтар зохион байгуулсан өртөөт зам “Монголын Морин Өртөө”-нөөс үүсэлтэй.

Монголын морин өртөө шуудан нь үүсэл хөгжлөөрөө дэлхийн шуудан холбооны түүхэнд анхдагч тэргүүн зэргийн харилцаа холбооны нэгэн төрөлд тооцогддог билээ.

Монгол улс дэлхийн асар өргөн уудам нутгийг эзлэн оршиж байсан үед **1228-1241 онд** Монголын эзэнт гүрний хаан ширээнд сууж байсан Чингис хааны гуравдугаар хөвгүүн Өгөдэй мэдээлэгч, захирагч нарыг бий болгож морин өртөө байгуулсан нь шуудан харилцааны хувьд уургын улааг халж, мэдээлэл харилцаа дамжуулах сүлжээг үүсгэн байгуулсан томоохон дэвшил билээ.

Өртөө нь улам боловсронгуй болон хөгжсөөр Ардын хувьсгал мандсан **1921 оны 7 дугаар сарын 19-нд** Ардын засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулсан нь одоогийн **99 жилийн түүхт Монгол Шуудан** юм.



Шуудан хуваарилах тасаг. 1950 он

1921-07-19

Ардын Засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулав.

1935

Нийслэлийн Шуудангийн хороо

1935-1936

Нийслэлийн Төв Холбооны Төв шуудан тасаг

1936-1958

Холбооны Ерөнхий Хорооны харьяа Төв Шуудан

1958-1960

Цахилгаан Шуудангийн хороо

1966-1978

Төв Шуудан

1978-1990

Цахилгаан Шуудан Холбооны газар

1990-1994

Шуудан Холбооны газар

1994

Монгол Шуудан ТӨУҮГ

2002

Монгол Шуудан ХХК

2009

Монгол Шуудан ТӨХК

2016

Монгол Шуудан ХК



Шууданч бүсгүй. 1980 он

ХУВЬЦААТ КОМПАНИД ШИЛЖСЭН ШИЙДВЭР:

1. Монгол Улсын Их Хурлын 2015 оны “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” 70 дугаар тогтоол
2. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 330 дугаар тогтоол
3. Төрийн өмчийн хорооны 2015 оны “Нэмэлт хувьцаа гаргах тухай” 594 дүгээр тогтоолуудаар “Монгол Шуудан” ХК болгон өөрчлөв.

ЦАР ТАХАЛ БА ХЯМРАЛЫН МЕНЕЖМЕНТ

COVID-19 вирус дэлхий нийтээр хурдтай тархаж, Пандемик (цар тахал)-ын түвшинд хүрээд буй нөхцөлд эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүдэд компанийн эдийн засгийг тогтворжуулах зорилгоор Хямралын менежмент"-ийн дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаа.

Цар тахлын үед яаралтай арга хэмжээ авах зорилгоор онцгой комиссыг байгуулан тогтмол онлайн хурлыг зохион байгуулж, холбогдох шийдвэр тогтоолыг гарган хямралын эсрэг горимд шилжин ажиллав.

Хямралын үед монгол шуудан компанийн баримтлах гол зарчим

ХҮН

- Ажилтны аюулгүй байдал, эрүүл мэнд
 - Ажилтнаа зайнаас ажилуулах
 - ХАБ-ын зөвлөмж
 - Уян хатан ажлын цагийн хуваарь
- Ээлжээр ажиллуулах тушаал шийдвэр
 - Ажлын байрны ариутгал, халдваргүйжүүлэлт
 - Хүн хоорондын зай

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ


- Хямралын үеийн санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэл
- Эрсдэлийг тооцоолсон хувилбарууд
- Эрсдэл бүрд авах багц хариу арга хэмжээнүүд
- Хөрөнгө оруулалт

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

- Хөл хорионы үед хэрэглэгчдэд хүрч үйлчлэх бодлого
- Шууданчдад цаг үеийн мэдээ мэдээлэл, зөвлөмж
 - Эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын комиссын хамтын ажиллагаа
 - Хувь хүн, Албан байгууллага засаг захиргааны нэгжүүдтэй хамтран ажиллах

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Орон нутгийн тээвэр Логистикийн нарийвчилсан төлөвлөгөө
- Хот доторх хүргэлт сайжруулах төлөвлөлт
- Улс хоорондын шуудангийн шинэчилсэн төлөвлөгөө
- Өндөржүүлсэн горимд мөрдөн ажиллах стратеги
- Тээвэр, түгээлтийн үйл ажиллагаа
- Тасралтгүй үйл ажиллагаа
- Шуудангийн үйлчилгээг хүн бүрт эрх тэгш байдлаар хүргэх цогц бодлого



МОНГОЛ ШУУДАН КОМПАНИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

2020 он

Нэгдүгээр сар	Дөрөвдүгээр сар	Зургаадугаар сар	Долдугаар сар	Наймдугаар сар
---------------	-----------------	------------------	---------------	----------------



➤ 2020 ОНЫ “БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ ТАНИЛЦУУЛАХ ХУРАЛ”

2020 оны 01 дүгээр сар

Компанийн бодлого, үйл ажиллагааны шинэчлэл, 2020 оны Зорилго, Төлөвлөлт Алсын хараа, үнэт зүйлсийг нийт ажилтнуудад сурталчлан таниулах ажилтнуудыг нэг зорилгод уриалан нэгтгэх хурлыг амжилттай зохион байгууллаа.



➤ КОВИДЫН ҮЕД ДАГАЖ МӨРДӨХ ТҮР ЖУРАМ ГАРГАВ

2020 оны 04 дүгээр сар

Цар тахлын үед ажилчид өөрийгөө болон ойр дотнын хүмүүсээ хамгаалах зөвлөмжийг хүргэж ажиллах цагийн хуваарийг уян хатан болгон ажлын байран дахь ачааллыг бууруулах зорилгоор түр журмыг гарган мөрдөн ажиллав.

ДИПЛОМ ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2020 оны 6 дугаар сар

Дэлхий дахинаа тархаад буй коронавируст халдварын цар тахлын улмаас 2020 оны нийт төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн дипломыг энгэрийн тэмдгийн хамт “Монгол шуудан” ХК эх орны өнцөг булан бүрт **21 аймаг 330 сумд** шууд эздийнх нь гарт гардуулав.



➤ ШАГНАЛ

2020 оны 7 дугаар сар


Компанийн Улаанбаатар болон орон нутаг, үе үеийн ахмад холбоочдын дундаас 2020 онд нийт **51** ажилтан Төрийн дээд болон Харилцаа холбоо, мэдээлэл технологи, шуудангийн салбарын шилдгээр шалгаран шагналыг гардуулав.



➤ ДЭЛХИЙН ШУУДАНГИЙН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТЭЭР ЧАНАР САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭВ

2021.07 дугаар сар

Дэлхийн Шуудангийн Холбооны үйлчилгээний чанарын сангаас “Улс хоорондын шуудан ялган боловсруулах төв ба нийслэлийн шуудангийн томоохон 10 салбарын хоорондох шуудан хүргэлтийг сайжруулах” - **42750 ам.доллар** буюу **120 орчим сая** төгрөгийн санхүүжилт бүхий төслийг амжилттай хэрэгжүүлж **0** гүйлттэй Тоёота Хиас маркийн **16** суудалтай тээврийн хэрэгслийн худалдан авалтыг санхүүжүүлсэн.



➤ ERP.E-MONGOLIA.MN

2020 оны 08 дугаар сар

Төрийн байгууллагуудын зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагааны зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд хүргэж буй үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй болгох ажлын хүрээнд **ERP программ** хангамжийн цогц системийг дотоодын үйл ажиллагаанд амжилттай нэвтрүүллээ.



➤ UNITEL-ХАМТЫН АЖИЛЛАГАА

2020 оны 08 дугаар сар

Бид өөрсдийн үйл ажиллагаа болон харилцаа холбооны салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Юнител групптэй хамтран **309** сумын салбар нэгжээрээ дамжуулан Юнителийн үйлчилгээг хүргэхээр болов.



➤ УЛС ХООРОНД ЯВУУЛАХ ШУУДАНГ ХАЯГААР АВДАГ БОЛЛОО

2020 оны 08 дугаар сар

Covid-19 Цар тахлын хүрээнд хэрэглэгчдэд илүү ойртох эрсдэлийг бууруулах зорилгоор ариутгал хийгдсэн тээврийн хэрэгслээр хэрэглэгчдэд үйлчлэх шинэ төрлийн үйлчилгээг амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна.



➤ EMS – ШИНЭ САЛБАРЫГ НЭЭВ

2020 оны 08 дугаар сар

“Монгол шуудан” компанийн үйлчилгээний нэг төрөл болох **/EMS/** буухиа шуудангийн үйлчилгээнд зориулсан анхны салбарыг амжилттай нээгээд байна.



➤ ЦАГААН САРЫН МӨНГӨНИЙ ДУГТУЙ

2020.01 дүгээр сар

Мөнгөний дугуйны загварыг шинэчлэн **20** гаруй төрлийн сонголттойгоор **380,000** орчим ширхгийг худалдаанд гарган борлууллаа.

ХЯМРАЛЫН ҮЕД МОНГОЛ ШУУДАН КОМПАНИЙН БАРИМТЛАХ ГОЛ ЗАРЧИМ

- Хүн**
 - Ажилтны авуулгүй байдал, эрүүл мэнд
 - Ажилтнаа зайлсаар ажиллуулах
 - ХАБ-ын зөвлөмж
 - Уян хатан ажлын цагийн үнэмлэх
 - Эхнэр ажиллуулах тушаал шийдвэр
 - Ажлын байрны ариутгал, агаардагчилуулалт
 - Хүн хоорондын зай
- Санхүүгийн байдал**
 - Хирийн үнийн санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэл
 - Эрсдэлийг тооцоолсон хувилбарууд
 - Эрсдэл бүрд авах багц харуу арга хэмжээнүүд
 - Харилцаа оролцол
- Нийгмийн харилцаа**
 - Хөл хорионы үед харилцаанд арга үйлчлэх бодлого
 - Шуудангад цаг үеийн мэдээ мэдээлэл, мөнгө
 - Эцэст мэндийн байгууллага, өнцөг байдлын комиссын хамтын ажиллагаа
 - Хувь хүн, Албан байгууллага засаг захиргааны нэгжүүдтэй хамтын ажиллагаа
- Үйл ажиллагааны тогтвортой байдал**
 - Сонирхлын төлөвлөлт
 - Хөг дотор хүргэлт сайжруулах төлөвлөлт
 - Улс хоорондын шуудангийн санхүүжилт төлөвлөгөө
 - Өндөржүүлсэн горимд мөрдөн ажиллах стратеги
 - Төлөв, түгээмэл үйл ажиллагаа
 - Тасралтгүй үйл ажиллагаа
 - Шуудангийн үйлчилгээг хүн бүрт зох тэгш байдлаар хүргэх цогц бодлого



МОНГОЛ ШУУДАН КОМПАНИЙН 2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



2020 он

ОНЦЛОХ

Есдүгээр сар

Аравдугаар сар

Аравдугаар сар

Арваннэгдүгээр сар

Арванхоёрдугаар сар



► БАЙГУУЛЛАГЫН ТАВАН ТӨРӨЛТ СПОРТЫН НААДАМ

2020 оны 09 дүгээр сар

Улаанбаатар хот болон орон нутгийн 112 ажилтан хамрагдан сагсан бөмбөг, хөл бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатрын төрлүүдээр Монгол Шуудан Компанийн спортын арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.



► ОЛОН УЛСЫН ШИНЭ ЯЛГАН БОЛОВСРУУЛАХ ТӨВИЙН БАРИЛГА

2020 оны 09 дүгээр сар

Харилцаа холбоо, мэдээлэл технологи, шуудангийн салбарын 100 жилийн ойгоор ашиглалтад хүлээн авах Хөшигийн хөндийн "Шинэ нисэх" буудалд баригдах "Монгол Шуудан" ХК-ийн Олон улсын шуудан ялган боловсруулах төвийн барилгын шав тавих ёслол амжилттай болж барилгын ажил хийгдэж байна.



► ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

2020 оны 09 дүгээр сар

Хүний нөөцийн чиг үүргүүдийг нарийвчлан тайлбарласан бодлогыг системтэйгээр хэрэгжүүлэх, тогтоон барих, ёс зүйн хэмжээг дээдлэн ажиллах, байгууллагын зорилгыг газар хэлтэс, ажилтан бүрийн зорилго зорилт руу чиглүүлэн үр ашигтай байгууллага, нэгдмэл харилцааг бэхжүүлэгч хамт олон бий болгох зорилгоор "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг боловсруулан Гүйцэтгэх захирлын А/188 тоот тушаалаар батлуулан мөрдөж эхлэв. >>



► ӨНӨӨДРИЙН ТЭМҮҮЛЭЛ 2020

2020 оны 09 дүгээр сар

2020 оны сургалт, идэвхжүүлэлтийн ажлын хүрээнд Улаанбаатар хотын ажилтнуудад өөрчлөлтийг чиглүүлэх зорилгоор "ӨНӨӨДРИЙН ТЭМҮҮЛЭЛ" сэдвээр сургалтыг зохион байгуулав.



► ДЭЛХИЙН 198 ОРНООС "МОНГОЛ ШУУДАН" ХК ШАЛГАРЛАА

2020 оны 10 дугаар сар

Нэгдсэн үндэстний байгууллагын агентлаг Дэлхийн шуудан холбоо /UPU/ нь гишүүн 198 орны үйлчилгээний чанарын нэгдсэн үзүүлэлт, хэрэглэгчид хандсан үйлчилгээний чанарын суурь шалгуур үзүүлэлт үйл ажиллагааг нарийвчлан дүгнэж байр эзлүүлдэг бөгөөд 2019 оны үзүүлэлтээр "Монгол Шуудан" ХК шалгаран Цом Сертификатаа хүлээн авлаа.



ДЭЛХИЙН
198 ОРНООС
ШАЛГАРЛАА



► EUROGIRO –ОЛОН УЛСЫН МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2020 оны 10 дугаар сар

"Монгол шуудан" Хувьцаат Компани, "Ард кредит" ББСБ хамтран дэлхийн 160 гаруй орны шуудангийн 400 мянга гаруй салбараас мөнгө хүлээн авах, гуйвуулга хийж шилжүүлэх олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2020 он 10 сар 02 өдрөөс албан ёсоор нэвтрүүлэв.

Eurogiro болон Financial super market системүүдийн тусламжтайгаар монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх төслийг хариуцан үйл ажиллагааг зохион байгуулж одоогоор дэлхийн 50 гаран оронтой шуудан мөнгөн гуйвуулгын үйлчилгээг үзүүлэх боломжийг бий болгосон.

► ШИНЭ АЖИЛТНЫ ОНЛАЙН СУРГАЛТ

2020 оны 10 дугаар сар

Шинэ ажилтны заавал мэдэж авах Компанийн бүтэц зохион байгуулалт үйл ажиллагааны чиглэл тухайн ажилтны ажлын байранд тавигдах шаардлага стандартын талаарх 10 төрлийн Видео хичээлүүдийг боловсруулан бэлтгэж үйл ажиллагаанд ашиглаж эхлэв. >>

Шинэ



МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО 780 ЖИЛ.

► ШИНЭ МАРК

2020 оны 11 дугаар сар

2020 онд сэдвийн төлөвлөгөөний дагуу 14 сэдвийн марк, дугтуй гаргаж, сурталчлах түгээх борлуулах мөн нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.



► ОНЛАЙН ЗАЙН СУРГАЛТ

2020 оны 12 дугаар сар

Ази-Номхон далайн Бүсийн Шуудангийн Байгууллагаас зохион байгуулж буй "Interactive Online Training Program" найман сэдвийг хамруулсан цуврал зайн сургалтад БХГ, СТГ, ХҮЛТ-1613, УХШГ-ын мэргэжилтнүүдийг хамруулсан.



► E-MONGOLIA


2020 оны 12 дугаар сар

Төслийн хүрээнд гадаад паспорт, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхийг "Монгол Шуудан" Хувьцаат Компаниар дамжуулан хүргэх, зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж эхлүүлэв.



ХҮНИЙ НӨӨЦ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ТАЛААР

Хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа

2020 оны жилийн эцсийн байдлаар компанийн хэмжээнд  7 газар, 6 хэлтэс, 6 төв,


Улаанбаатар хотод 35 салбар, аймаг орон нутагт

22 шуудангийн үйлчилгээний газар,

331 сумдад нийт

987

ажилтан ажиллаж байна.



Аймгийн шуудангийн үйлчилгээний газарт

517




Улаанбаатар хотод


470

“Монгол Шуудан” ХК-ийн нийт ажиллах хүчний 48% нь Улаанбаатар хотод 52% нь орон нутгийн шуудангийн үйлчилгээний газарт ажиллаж байна. Компанийн хэмжээнд 2020 онд Улаанбаатар хот болон орон нутгийн салбарт хүүхэд асрах чөлөөтэй 30 хүн, жирэмсний амралттай 21, урт хугацааны чөлөөтэй 12, нийт 987 ажилтантай ажиллав.

Хүйсийн хувьд авч үзвэл, 67% хувь нь эмэгтэй, 33% хувь нь эрэгтэй ажилтан байна. Энэ нь 2019 онтой харьцуулбал нийт ажилтны хувийн жин 6.7% иар өссөн.



Нийт ажилтаны тоо



Ажлын байрны дундаж насжилт




Компанийн ажилтнуудын дундаж насжилт 2018, 2019 онуудад 39, 2020 онд 35 болж залуужсан байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

2020 ОНЫ ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

2020 оны 09 сард Монгол шуудангаар үйлчлүүлж байгаа албан байгууллага болон хувь хүнээс үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгаа авахад шуудангийн үйлчилгээний чанарт албан байгууллага **87,6%** сайн, Хувь хэрэглэгчид **60,8%** дундаж гэх үнэлгээнүүдийг өглөө.



CALL CENTER-Н ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАВ

Шуудангийн **Лавлах 1800-1613** төвөөр үйлчлүүлж буй иргэдийн ачааллыг бууруулах үйлчлүүлэгчийн дуудлагын хянах, дуудлага алдахгүй байх хэрэгцээт асуултад цаг алдалгүй хариулах зорилгоор **КоллПро** үйлчилгээг нэвтрүүлэв.

Нийт хандсан дуудлагууд

278,332

Нийт гадагш залгасан дуудлагууд

28,104



Нэг дуудлагын дундаж хугацаа

1 минут 35 секунд

Лавлах утас руу орж ирсэн дуудлага
1800-1613

215,721

Нийт дуудлага

1800-1613

7007-1613

77,5%

22.5%

07-р сарын 01-нээс ДШХ-ООС БУУХИА ШУУДАНГИЙН "I-care" лавлагааны шинэ системийг нэвтрүүлсэн бөгөөд ХҮЛТ-ийн операторууд нь онлайн сургалтад хамрагдснаар тус системийг бүрэн ашиглаж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЛАВЛАХ ТӨВ 1800-1613



Харилцах утсаар дуудлага хүлээн авсан

215,721



Үйлчилгээний заалаар

2,367

Байгууллагын веб сайтын чатаар



3,559



Дотоод сүлжээгээр

1,393



Компанийн фэйсбүүк хуудсаар

6,960

2020 онд нийт

230,000

хандалт ирж дээрх 5 төрлийн сувгаар тухай цаг хугацаанд хэрэглэгчдийн сонирхсон асуултууд мэдээлэл хүргэн ажиллаа.

ХЭРЭГЛЭГЧЭЭС ШУУДАН ГАРДУУЛАЛТ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ЗӨРЧИЛТЭЙ холбоотой гомдол

58

ХҮРГЭЛТ ГАРДУУЛАЛТЫН ХУРД НЭМЭГДҮҮЛЭХ талаар гомдол

42

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ЗАН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ гомдол

66 гэх мэт нийт

241

гомдлыг дээрх 5 сувгаар дамжуулан хүлээн авч холбогдох газруудад нь мэдэгдэн, шийдвэрлэж ажилласан байна.

Мөн БҮРТГЭГДСЭН ИЛГЭЭМЖИЙН ЛАВЛАГААНЫ **Прайм системийг** үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглаж байна.




ШУУДАНГИЙН ТЕХНОЛОГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

УЛС ХООРОНДЫН ШУУДАНГИЙН СҮЛЖЭЭНИЙ АШИГЛАЛТ ТАСРАЛТГҮЙ,
НАЙДВАРТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ТАЛААР



Стандартуудын мөрдөлтийг хангах, хүргэлтийг сайжруулах

Дэлхий даяар цар тахлаас шалтгаалсан хүндрэлүүд үүсч, дэлхийн улс орнууд давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд автсанаа зарласан бөгөөд ДШХ болон Буухиа шуудангийн кооперативаас хийлгэдэг 2020 оны чанарын үнэлгээг цуцалсан. Иймээс цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан улс хоорондын шууданд гарч буй аливаа хүндрэл бэрхшээл, шуудангийн саатлыг арилгах тал дээр анхаарч ажилласан бөгөөд мөн стандартуудын мөрдөлтийг хангах зорилт тавин ажиллалаа.



Хүргэлтийн саатлыг бууруулах

Гарах буухиа шуудангийн хүргэлт гардуулалтын явц дунд гарсан төлөвлөгдөөгүй саатал үүссэн нөхцөл байдлыг илгээгчид тухай бүрт мэдэгдэж, саатлыг арилгах боломжуудыг эрэлхийлж, асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.



Тээврийн маршрутыг оновчлох

Өмнөх жилүүдээс ялгаатай нь тогтмол нислэгийн хуваарьгүй ажиллаж, **МИАТ, Туркиш Эйрлайнс, Эйр Инчеон, Кореейн Эйр, АНА** компаниудтай нягт хамтран ажилласнаар 2020.03.16-наас он дуустал 87 удаагийн нислэгээр, 10 гаруй улсад давхардсан тоогоор 120 чиглэлд шуудан гаргалаа. Улс орнууд руу илгээж буй бүх төрлийн илгээмжийн маршрут чиглэлийг тухай бүрт өөрчлөх, дамжин өнгөрүүлэх улс орны шуудангууд болон тээврийн байгууллагатай удаа бүрт нь холбогдон ажиллалаа.



Технологийн зөрчилгүй ажиллах

Улс хоорондын шуудангийн бүх шат дамжлагуудад аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор заавар зөвлөмжүүдийг дотоод мэдээллийн сайт дээр байршуулах, дотоод сүлжээгээр анхааруулж мэдээлэн ажилласан ба нийт **251** зөрчлийг илрүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулан ажиллалаа.

Мөн улс хоорондын сүлжээний болон илгээмжийн аюулгүй байдлыг ханган, **УХШИГГ, Хилийн мэргэжлийн хяналттай хамтран ажиллалаа.**

Болзошгүй зөрчил, гэмт хэргээс сэргийлж ажиллах талаар улирал тутам зааварчилгаа өгч, хяналтын бүсэд ажилладаг ажилтан бүрээр баталгаа гаргуулан ажилласан бөгөөд зөрчил дутагдал гаргасан ажилтнуудад зохих хариуцлагыг тооцон арга хэмжээ авч ажилласан.




Технологийн процессыг шинэчлэх

Шуудангийн хэрэглэгдэхүүнийг захиалан үйлдвэрлүүлэх ажлыг гүйцэтгэж, илгээлтийн хаягийн шошгын маягт **CP72**, дунд болон том хэмжээтэй EMS болон компанийн логотой хулдаасан дугуйг БНХАУ-д захиалан хийлгүүлсэн.




УЛС ХООРОНДЫН ШУУДАНГИЙН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

2020 оны улс хоорондын **гарах** шуудангийн солилцоог 2019 онтой харьцуулахад



БИЧИГ ЗАХИДАЛ, ИЛГЭЭЛТ БУУХИА ШУУДАНГИЙН СОЛИЛЦООНЫ МЭДЭЭЛЭЛ

2020 оны улс хоорондын **орох** шуудангийн солилцоог 2019 онтой харьцуулахад давтамжийн тоо эрс багасч,



ДОТООД ШУУДАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

ШУУДАН СОЛИЛЦООНЫ БҮРТГЭЛ, СУДАЛГАА

Илгээмж тус бүрээр задалбал,

БУУХИА ШУУДАН

 **52,562** ширхэг



БИЧИГ ЗАХИДАЛ

1,871,431 ширхэг



ИЛГЭЭЛТ

68,717 ширхэг



ХЭВЛЭЛ

8,810,027 ширхэг

тус тус ялган боловсруулж, хүргэжээ.


Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, сүлжээний байнгын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах үйл ажиллагааны хүрээнд орох, гарах чиглэлд **155,469** ширхэг богц буюу **1,027 тн** шуудан ялган боловсруулж, хүргэлээ. Үүнээс өөрийн тээврээр бүх аймагт **18,934** богцоор **194 тн** шуудан тээвэрлэж хүргэсэнээр дээрх чиглэлийн шуудангийн илгээмжийн аюулгүй байдал, хяналтын хугацаа, хүргэлтийн чанар сайжирлаа.

ШУУДАНГИЙН СААТАЛ

Сааталтай хүргэгдсэн шуудангийн илгээмжийн тоо хэмжээ нь нийт солилцооны

 **2,1%** -ийг эзэлж байна.

СААТСАН ИЛГЭЭМЖИЙН ТОО



● Солилцооны тоо ● Саатсан илгээмж

ТЭЭВЭР ЗУУЧ, ЛОГИСТИКИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД



ХИЛ ДАМНАСАН И-ХУДАЛДАА БУЮУ ТРАНЗИТ ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД



- Цар тахлын нөлөө, хил гаалийн хорио цээрийн үед авто зам, төмөр замын хосолсон тээврийг тогтмол хийж, үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулав
- **ОХУ-Монгол, ОХУ-БНХАУ** чиглэлийн тээврийг амжилттай нээж, туршилтын тээврийг зохион байгууллаа
- **БНХАУ- ОХУ** чиглэлийн агаарын транзитыг амжилттай гүйцэтгэлээ
- **Bonded warehouse** шинэ бизнес хөгжүүлэлтийн хамтын ажиллагааг эхлүүллээ
- 2020 онд нийт **2,405 тонн, 18.6 сая** илгээмжийг Монгол улсаар дамжуулан тээвэрлэлээ

ХОТ ДОТОРХ ХҮРГЭЛТ БУЮУ ГАРААС-ГАРТ ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД



- 21 аймагт тогтмол тээврийг үе шаттай эхлүүлсэн (**долоо хоногт 1-5 удаагийн давтамжтай тээвэр гүйцэтгэж байна**)
- Хөл хорионы үед шуудан, ачаа тээврийн тасралтгүй байдлыг хангаж ажилласан
- Сонгуулийн үеэр хариуцлагатай ачаа тээврийг амжилттай гүйцэтгэв
- **Орон нутаг – Улаанбаатар** чиглэлийн логистик орлогыг нэмэгдүүлсэн
- том оврын **10** тонныг даацтай **2** автомашинаар хүчин чадлаа нэмэгдүүлсэн
- Нийт **382** удаа тээвэр гүйцэтгэж, **1,710** тонн шуудан, ачаа тээвэрлэлээ



ХОТ ХООРОНДЫН АЧАА ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ





- Хүчин чадлаа нэмэгдүүлж, хотын хүргэлтийн **22** машинтай боллоо
- **MyDelivery** онлайн захиалгын систем нэвтрүүлээ, улмаар хэрэглэгчид хүссэн газраасаа шуудангийн захиалга өгч, төлбөр тооцоогоо хийдэг боллоо
- Хотын доторх хүргэлт **4-8 цагт** хийдэг боллоо
- Харилцагч байгууллагын тоо **2** дахин нэмэгдэж **60** харилцагчтай боллоо
- Гараас гарт үйлчилгээг зах зээлд таниулж ажилласан



САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

“Монгол шуудан” ХК нь Ард Кредит ББСБ-тай хамтран Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний томоохон системүүдийн нэг болох **ЕвроЖайро системд** нэгдэн орсноор Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2020 оны 08 сараас 2020 оны 12 сарын 31-ны байдлаар нийт **13** оронтой **75** удаагийн гүйлгээгээр **113,400,000₮**-н гүйлгээг амжилттай хийгээд байна.



“ЦАХИМ ШИЛЖИЛТ” АЖЛЫН ХҮРЭЭНД

ПРОГРАММ ХАНГАМЖ ХӨГЖҮҮЛЭЛТ, ХЭВИЙН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ



Гардуулалтын
мобайл
аппликейшнд
хөгжүүлэлт болон
техникийн хангамжийн
сайжруулалт хийгдсэн.



2020 оны 4-р сард
Монгол шуудан ХК-ийн
хувьцаа эзэмшигчдийн
хуралд зориулж
**Онлайн хурлын
програм хангамж**
хөгжүүлсэн.

2020 онд ШҮС-ын
119 шууданчид гар
утасны **гардуулалтын
аппликейшн**
ашиглан **887,153ш**
илгээмж гардуулсан.

Дотоод шуудан
бүртгэлийн
ПОСТНЕТ системийн
серверүүдэд
техникийн шинэчлэл
хийсэн.

Постнет – IPS систем
хоорондын холболт
болон **API**-ийн
хөгжүүлэлтүүдийг
хийсэн.

GPS хяналтын
програмыг Автобаазын
50 машинд, түлш
хэмжигч төхөөрөмжийг
2 машинд суурилуулан
ашиглаж байна.



Цахим үйлчилгээний нэгдсэн
систем **E-Mongolia** төрийн
үйлчилгээний **иргэний
үнэмлэх, жолооны
үнэмлэх, гадаад паспорт**
захиалгын хүргэлтийг
нэвтрүүлэх ажлын
хөгжүүлэлтийг амжилттай
хийж гүйцэтгэсэн.



МОНГОЛ
ШУУДАН



МАРК
ҮНЭТ ЦААСНЫ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖЛЫН
ХҮРЭЭНД

Фото зургийг Төгөл
Говь-Алтай

МАРК бүр
ТҮҮХ ӨГҮҮЛДЭГ

2020 онд сэдвийн төлөвлөгөөний дагуу **14 сэдвийн марк, дугуй** гаргаж, сурталчлах түгээх борлуулах мөн нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.



ХУЛГАНА ЖИЛ. 1059



ДЭЛХИЙН АНХНЫ ШУУДАНГИЙН МАРКИЙН
180 ЖИЛИЙН ОЙ. 1059



МОНГОЛЫН УРАН БАРИЛГА. 1061



МОНГОЛЫН УРАН БАРИЛГА.
1062



АУГАА ИХ ЭХ ОРНЫ ДАЙНД
ЯЛСНЫ 75 ЖИЛ. 1063



МОНГОЛ ОРНЫ ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗАР-3. 1064



МОНГОЛЫН ОЛИМПЫН МЕДАЛЬТНУУД. 1065



МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО 780 ЖИЛ. 1066



МОНГОЛ-СЛОВАКИЙН ХАМТАРСАН МАРК. 1068



МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО 780 ЖИЛ. 1067



МОНГОЛ-СИНГАПУРЫНН ХАМТАРСАН МАРК. 1069



ЛЮДВИГ ВАН БЕТХОВЕНЫ МЭНДЭЛСНИЙ 250 ЖИЛИЙН ОЙ. 1070



МОНГОЛ УЛС
БҮГД НАЙРАМДАХ
ЭНЭТХЭГ УЛСТАЙ
ДИПЛОМАТ
ХАРИЛЦАА
ТОГТООСНЫ 65
ЖИЛ. 1071



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ.
1072

АНХНЫ ӨДРИЙН ДУГТУЙ



ХУЛГАНА ЖИЛ. 1059



МОНГОЛЫН ОЛИМПЫН МЕДАЛЬТНУУД. 1065



МОНГОЛЫН УРАН БАРИЛГА. 1061



МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО 780 ЖИЛ. 1066/67



АУГАА ИХ ЭХ ОРНЫ ДАЙНД ЯЛСНЫ 75 ЖИЛ. 1063



МОНГОЛ-СЛОВАКИЙН ХАМТАРСАН МАРК. 1068



МОНГОЛ-СИНГАПУРЫНН ХАМТАРСАН МАРК. 1069



МОНГОЛ ОРНЫ ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗАР- 3. 1064



ЛЮДВИГ ВАН БЕТХОВЕНЫ МЭНДЭЛСНИЙ 250 ЖИЛИЙН ОЙ. 1070




МОНГОЛ УЛС БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 65 ЖИЛ. 1071

МӨНГӨНИЙ ДУГТУЙ

Загвар: 20 төрөл



Хуурч өвгөн



Морин хуурь



Хадаг барьсан охин



Бурханы найман тахил



Морин эрдэнэ



Гэрийн тооно



Эвтэй дөрвөн амьтан



Хулгана жил



Баян-Намсрай



Мөнгөн аяга, хос домбо



Чингис хаан



Есөн цагаан туг



Хэт хутага



Аз жаргал хүсэе



Дөрвөн хүчтэн




Хангарьд



Арслан



Хүннү дээл



Хээ




Цагаан өвгөн

САНХҮҮ ЭДИЙН
ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ШУУДАНГИЙН НИЙТ СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Нийт солилцоо	1,571,830	1,757,660	2,302,599	2,653,661	2,399,497
ДОТООД	1,102,770	1,288,531	1,590,703	2,082,944	2,108,296
БИЧИГ ЗАХИДАЛ	1,050,051	1,122,595	1,512,814	2,009,719	2,002,527
БООДОЛ	28,554	46,054	55,928	51,766	60,102
ИЛГЭЭЛТ	24,165	24,882	21,961	21,459	45,667
УЛС ХООРОНД	469,060	469,129	711,896	570,717	291,201
УЛС ХООРОНД ГАРАХ	230,098	204,502	177,930	191,276	60,491
УЛС ХООРОНД ОРОХ	238,962	264,627	533,966	379,441	230,710

Ширхэг




Нийт солилцоо: 2020 онд өмнөх жилээс **9.6** хувиар буурсан ↓

ДОТООД ШУУДАНГИЙН СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТ



Дотоод нийт солилцоо: 2020 онд өмнөх жилээс **1.2** хувиар өссөн ↑

УЛС ХООРОНД ШУУДАНГИЙН СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТ



Гадаад нийт солилцоо: 2020 онд өмнөх жилээс **49.0** хувиар буурсан ↓

ОРЛОГО, ЦЭВЭР АШИГ


2016-2020 ОН

Нэгж: Сая.төгрөг

Дансны нэр	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Нийт орлого	11,923.1	13,672.6	15,474.0	16,725.0	18,231.9
Татварын дараах цэвэр ашиг	1,006.6	1,224.2	1,560.3	1,103.6	557.9


НИЙТ ОРЛОГО

Нэгж: Сая.төгрөг




ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ

Нэгж: Сая.төгрөг




НИЙТ ХӨРӨНГӨ

2016-2020 он





Тус компанийн нийт активын хэмжээ 2020 оны жилийн эцэст **37,366.3** сая төгрөгт хүрч урьд оныхоос **11.6** хувиар өссөн байна.



Компанийн эргэлтийн хөрөнгө 2019 онд нийт хөрөнгийн **73.1** хувийг эзэлж байсан бол 2020 онд **73.9** хувь болон өссөн байна.

НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

2016-2020 он



2020 оны жилийн эцсийн богино хугацаат өр төлбөр **13,389.8** сая төгрөгт хүрч, өмнөх жилээс **26.8** хувиар өссөн бол хуримтлагдсан ашгийн хэмжээ **4,425.6** сая төгрөгт хүрч, 2019 оноос **2.1** хувиар өсчээ .

САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТ


2019-2020 он

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 он	2020 он
Цэвэр ашиг	<i>төгрөг</i>	1,103,559,718.68	557,893,342.52
Нийт хувьцааны тоо	<i>ширхэг</i>	99,586,363	99,586,363
Нэгж хувьцааны үнэ	<i>төгрөг</i>	725.0	750.0
Нэгж хувьцааны дансны үнэ	<i>төгрөг</i>	230.2	240.8
Зах зээлийн үнэлгээ	<i>тэрбум төгрөг</i>	72.2	74.7
Нэгж хувьцааны өгөөж /EPS/	<i>төгрөг</i>	11.1	5.6
Нийт хөрөнгийн өгөөж /ROA/	-	0.0333	0.0149
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROA/	-	0.0481	0.0233
Нийт хөрөнгийн эргэц /ROTA/	-	0.0368	0.0149

ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ АРИЛЖАА

2020 он

ХУВЬЦААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2020 онд нийт
153 өдрийн арилжаанд
идэвхтэй байж,

2020.01.02 - **699.00** төгрөгийн нээлтийн
ханштайгаар эхэлж,
2020.02.31 - **750.00** төгрөгт хүрч тайлант
оны арилжааг хаалаа


Компанийн Хөрөнгийн бирж дээрх үнэлгээ **72.2 тэрбум** төгрөгөөс оны эцсийн
байдлаар **3.5** хувиар өсч **74.7 тэрбум** төгрөгт хүрээд байна.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2019-2020 он

2020 оны жилийн эцсийн байдлаар компанийн нийт хувьцааны **66** хувийг Төрийн өмч, **30.94** хувийг Ард Санхүүгийн Нэгдэл ба түүний хамаарал бүхий этгээд, **3.06** хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна



МОНГОЛ
ШУУДАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН
БАЙДЛЫН ТАЙЛАН

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18-р зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гарсан.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020-12-31-нээр дуусвар болсон санхүүгийн тайлан

Үзүүлэлт	2019.12.31	2020.12.31
1 ХӨРӨНГӨ		
1.1 Эргэлтийн хөрөнгө		
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	16,648,915,943.48	21,058,975,785.26
1.1.2 Дансны авлага	4,345,338,954.87	2,067,693,154.84
1.1.3 Татвар, НДШ – ийн авлага	7,148,982.18	10,031,256.50
1.1.4 Бусад авлага	888,913,568.81	512,055,439.37
1.1.5 Бусад санхүүгийн хөрөнгө		7,769,001.00
1.1.6 Бараа материал	2,383,652,392.52	2,553,870,300.61
1.1.7 Урьдчилж төлсөн зардал/тооцоо	189,433,604.75	1,395,652,267.27
1.1.8 Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10 Хангамжийн материал		
1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн	24,463,403,446.61	27,606,047,204.85
1.2 Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1 Үндсэн хөрөнгө	8,725,816,424.32	8,252,460,198.96
1.2.2 Биет бус хөрөнгө	294,796,411.15	1,507,283,452.69
1.2.3 Биологийн хөрөнгө		
1.2.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
1.2.5 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6 Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8 Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9 Дуусаагүй барилга		
1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,021,112,835.47	9,760,243,651.65

1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,484,516,282.08	37,366,290,856.50
2 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
2.1.1 Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1 Дансны өглөг	9,560,914,328.30	12,553,826,567.10
2.1.1.2 Цалингийн өглөг	0.29	
2.1.1.3 Татварын өр	143,669,465.47	137,217,133.61
2.1.1.4 НДШ - ийн өглөг		
2.1.1.5 Богино хугацаат зээл		
2.1.1.6 Хүүний өглөг		
2.1.1.7 Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	569,653,929.72	433,009,216.64
2.1.1.9 Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	286,684,498.64	265,758,032.37
2.1.1.11 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12 Бусад өглөг		-
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,560,922,222.42	13,389,810,949.72
2.1.2 Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1 Урт хугацаат зээл		
2.1.2.2 Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3 Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5		
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2 Өр төлбөрийн нийт дүн	10,560,922,222.42	13,389,810,949.72
2.3 Эздийн өмч		
2.3.1 Өмч: - төрийн	6,572,700,000.00	6,572,700,000.00
2.3.2 - хувийн	3,385,936,300.00	3,385,936,300.00
2.3.3 - хувьцаат		
2.3.4 Халаасны хувьцаа		
2.3.5 Нэмж төлөгдсөн капитал	2,538,512,210.45	2,538,512,210.45
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919,523.85	3,379,919,523.85
2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	2,710,106,959.73	3,673,789,311.73
2.3.9 Хуримтлагдсан ашиг	4,336,419,065.63	4,425,622,560.75
2.3.10 Тайлант үеийн ашиг/алдагдал		
2.3.11 Эздийн өмчийн дүн	22,923,594,059.66	23,976,479,906.78
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	33,484,516,282.08	37,366,290,856.50

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020-12-31-нээр дуусвар болсон санхүүгийн тайлан

Үзүүлэлт	2019.12.31	2020.12.31
1 Борлуулалтын орлого (цэвэр)	15,465,766,821.01	16,355,718,391.34
2 Борлуулалтын өртөг	14,465,061,535.25	16,655,138,083.86
3 Нийт ашиг (алдагдал)	1,000,705,285.76	(299,419,692.52)
4 Түрээсийн орлого	127,345,944.06	120,128,315.75
5 Хүүний орлого	747,571,028.84	720,248,122.37
6 Ногдол ашгийн орлого		
7 Эрхийн шимтгэлийн орлого		
8 Бусад орлого		
9 Борлуулалт, маркетингийн зардал		
10 Ерөнхий ба удирдлагын зардал	838,289,158.16	860,136,874.60
11 Санхүүгийн зардал		
12 Бусад зардал	203,221,959.84	86,724,031.47
13 Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	378,236,702.28	1,035,328,449.34
14 Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	6,090,000.00	493,865.89
15 Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16 Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17 Бусад ашиг (алдагдал)		
18 Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,218,437,842.94	629,918,154.76
19 Орлогын татварын зардал	114,878,124.26	72,024,812.24
20 Татварын дараах ашиг (алдагдал)	1,103,559,718.68	557,893,342.52
21 Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22 Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,103,559,718.68	557,893,342.52
23 Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
24 Орлогын нийт дүн	1,103,559,718.68	557,893,342.52
25 Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Төгрөг

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020-12-31-нээр дуусвар болсон санхүүгийн тайлан

Үзүүлэлт	2019.12.31	2020.12.31
1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1 Мөнгөн орлогын дүн (+)	50,675,111,233.10	117,563,838,566.70
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	12,999,975,738.63	14,934,545,637.15
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	27,541,779.00	8,309,399.80
Буцаан авсан албан татвар		341,852.00
Татаас, санхүүжилтийн орлого	3,076,746,737.76	3,724,050,463.00
Бусад мөнгөн орлого	34,570,846,977.71	98,896,591,214.75
1.2 Мөнгөн зарлагын дүн (-)	50,402,573,835.85	113,488,133,606.84
Ажиллагчдад төлсөн	6,300,045,005.00	6,927,674,591.59
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,790,605,298.39	1,976,469,979.84
Бараа материал худалдан авахад төлсөн	2,034,093,179.39	2,339,771,129.81
Ашиглалтын зардалд төлсөн	1,284,790,198.09	1,339,415,155.89
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,793,325,608.03	4,361,498,754.90
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	1,115,206,307.45	1,033,489,574.41
Даатгалын төлбөрт төлсөн	37,935,662.00	50,489,205.98
Бусад мөнгөн зарлага	35,046,572,577.50	95,459,325,214.42
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	272,537,397.25	4,075,704,959.86
2 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1 Мөнгөн орлогын дүн (+)	607,002,945.57	948,348,112.46
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Хүлээн авсан хүүний орлого	607,002,945.57	948,348,112.46
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,529,755,538.61	1,678,712,634.65
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,501,305,538.61	1,466,209,639.30
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,450,000.00	202,503,995.35
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		9,999,000.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(922,752,593.04)	(730,364,522.19)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Бусад		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	577,675,719.04	317,441,948.34
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг	451,294,040.74	317,441,948.34
	Бусад	126,381,678.30	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(577,675,719.04)	(317,441,948.34)
	Валютын ханшийн зөрүү	609,723,794.71	1,382,161,352.45
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(618,167,120.12)	4,410,059,841.78
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,267,083,063.60	16,648,915,943.48
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,648,915,943.48	21,058,975,785.26

Төгрөг

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	Үзүүлэлт	Өмч	Халгаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2018-12-31-ний үлдэгдэл	9,958,636,300.00		2,538,512,210.45	3,379,919,524		2,710,106,959.73	3,925,316,261.18	22,512,491,255.21
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(224,384,918.80)	(224,384,918.80)
3	Залруулсан үлдэгдэл	9,958,636,300.00	-	2,538,512,210.45	3,379,919,524	-	2,710,106,959.73	3,700,931,342.38	22,288,106,336.41
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							1,103,559,718.68	1,103,559,718.68
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт							(468,071,995.43)	(468,071,995.43)
7	Зарласан ногдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	2019-12-31-ний үлдэгдэл	9,958,636,300.00	-	2,538,512,210.45	3,379,919,523.85	-	2,710,106,959.73	4,336,419,065.63	22,923,594,059.66
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(151,247,899.03)	(151,247,899.03)
11	Залруулсан үлдэгдэл	9,958,636,300.00	-	2,538,512,210.45	3,379,919,524	-	2,710,106,959.73	4,185,171,166.60	22,772,346,160.63
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							557,893,342.52	557,893,342.52
13	Бусад дэлгэрэнгүй орлого								-
14	Өмчид гарсан өөрчлөлт							963,682,352	963,682,352.00
15	Зарласан ногдол ашиг							(317,441,948.37)	(317,441,948.37)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
17	2020-12-31-ний үлдэгдэл	9,958,636,300.00	-	2,538,512,210.45	3,379,919,523.85	-	3,673,789,311.73	4,425,622,560.75	23,976,479,906.78

Төгрөг



УЛААНБААТАР ДАХЬ САЛБАРУУД

Салбар, нэгжийн нэр Байршил, хаяг

Утас

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

Тэнгис салбар 38	МАХН-ын байр, Л.Лааганы гудамж, ЧД, V хороо, УЛААНБААТАР 15141	70078938
-------------------------	--	-----------------

7 буудал Далайхүү салбар 40	“Далайхүү” худалдааны төвийн байр, 1 давхар, Чингэлтэйн өргөн чөлөө, ЧД, XIII хороо, УЛААНБААТАР 15110	357204
------------------------------------	--	---------------

ХАН-УУЛ ДҮҮРЭГ

Яармагийн хуучин эцэс салбар 30	Яармагийн хуучин эцэст, Нүхтийн гудамж-1, ХУД, VI хороо, УЛААНБААТАР 17110	70078930
--	--	-----------------

Нисэх салбар 34	“Чингис хаан” ОУ-ын нисэх буудал 2 давхарт, ХУД, X хороо, УЛААНБААТАР 17120	70049906
------------------------	---	-----------------

Хан-Уул АПУ салбар 36	ХУД, 2-р хороо, Хан-Уул хотхон, 5-р байр, үйлчилгээний 101 тоот	70078936
------------------------------	---	-----------------

Гурван оргил салбар 53	63-р байр, 1 тоот, “Гурван оргил” хотхон, ХУД, XI хороо, УЛААНБААТАР 17012-0043	70078953
-------------------------------	---	-----------------

СҮХБААТАР ДҮҮРЭГ

Төв шуудан салбар	Сүхбаатарын талбай 1, Энхтайваны өргөн чөлөө, ЧД, I хороо, УЛААНБААТАР 15160-0026	70078975
--------------------------	---	-----------------

1-р төрөх салбар 65	СБД, 1-р хороо, 1-төрхийн зүүн урд талд, Азмон центрийн 1 давхарт	“88002373 99147978”
----------------------------	---	----------------------------

11-р хороолол салбар 20	5а байр, XI хороолол, Эрхүүгийн гудамж, СБД-ийн VII хороо, УЛААНБААТАР 14192-0012	70078920
--------------------------------	---	-----------------

Централ таур салбар 20А	Централ таур, 1-р давхарт, СБД, VIII хороо, УЛААНБААТАР 14200-0040	77008919
--------------------------------	--	-----------------

Дамбадаржаа салбар 42	“Хүүхэд-элгэмсэг” ТББ-ын байр, 1 давхар СБД, XV хороо, УЛААНБААТАР 14010	94923178
------------------------------	--	-----------------

Улаанбаатар их дэлгүүр салбар 44	50 мянгатын 20 дугаар байр, Энхтайваны өргөн чөлөө, СБД, IV хороо, УЛААНБААТАР 14250	70078944
---	--	-----------------

Төрийн ордон салбар 46	Бага тойруу-1, Залуучуудын өргөн чөлөө, /Төрийн ордны хойд талд/ СБД, VI хороо, УЛААНБААТАР 14201	70078946
-------------------------------	---	-----------------

СОНГИНО ХАЙРХАН ДҮҮРЭГ

Хархорин салбар 21	“Пирамид” үйлчилгээний төв, I хороолол, Энхтайваны өргөн чөлөө, СХД, XVII хороо, УЛААНБААТАР 18032-0020	70078921
---------------------------	---	-----------------

Баянхошуу жанцан салбар 25	GMG үйлчилгээний төв, 2 давхарт, Баянхошууны гудамж-2, СХД-ийн IX хороо, УЛААНБААТАР 18010	306110
-----------------------------------	--	---------------

Лаборатори салбар 37	5 шар, Үйлдвэрчний эвлэлийн гудамж, СХД, XVIII хороо, УЛААНБААТАР 18080	70078937
-----------------------------	---	-----------------

Толгойт Сэлэнгэ зах салбар 64	“Сэлэнгэ” Зах худалдааны төв 1 давхар, Толгойтын гудамж-45, СХД, 20-р хороо, УЛААНБААТАР 18102	99041554
--------------------------------------	--	-----------------

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

Цайз 16 салбар 22	16-р хороолол, Сүмбэр худалдааны төвийн 1 давхарт, Монгол хотхон	89708922
--------------------------	--	-----------------

Цагдаагийн академи салбар 32	Цагдаагийн Академийн 1-р 48 айлын байрны 3-р орцны 25 тоот (урагшаа гаргасан өргөтгөлд), Энхтайваны өргөн чөлөө, БЗД, VIII хороо, УЛААНБААТАР 13260	70078932
-------------------------------------	---	-----------------

Натур салбар 48	Натур худалдааны төв, 79-р байр, 1-р давхарт, Манлайбаатар Дамдинжавын гудамж, БЗД, 25-р хороо, УЛААНБААТАР 13374 0015	70078948
------------------------	--	-----------------

Сансар салбар 49	“Сансар” үйлчилгээний төв 2 давхар, БЗД, III хороо, УЛААНБААТАР 13381 0097	70078949
-------------------------	--	-----------------

Хоме плаза салбар 63	Монгол улс, Улаанбаатар хот 17011, ХУД, 15-р хороо, Хоум плаза, 1 давхарт	8880-1620
-----------------------------	---	------------------

Жуков салбар 51	МЦХ ХК-ийн байр, Жуковын гудамж-1, БЗД, V хороо, УЛААНБААТАР 13343-0020	70078951
------------------------	---	-----------------

БАЯНГОЛ ДҮҮРЭГ

Хороололын эцэс салбар 23	IV хорооллын эцэст, Ард Аюушийн өргөн чөлөө, БГД, VII хороо, УЛААНБААТАР 16092	70078923
----------------------------------	--	-----------------

3-4-р Хороолол Алтан төгрөг салбар 24	“Визард говь” ХХК-ний байр, IV хороолол, Энэбишийн өргөн чөлөө, БГД, XIX хороо, УЛААНБААТАР 16066	70078924
--	---	-----------------

25-р эмийн сан Хаан даатгалтай байрны салбар 26	Тэнүүн 390-р байр, Хаан даатгалтай байрны 1-давхарт, БГД, 4-р хороо,	70078926
--	--	-----------------

Төмөр зам салбар 35	“Улаанбаатар” Төмөр замын төв буудал, 1 давхарт, БГД, I хороо, УЛААНБААТАР 16051	70078935
----------------------------	--	-----------------

ХӨДӨӨ, ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАРУУДЫН УТАС




АРХАНГАЙ	70333215
БАГАНУУР	70210531
БАЯН-ӨЛГИЙ	70422756
	70423031
БАЯНХОНГОР	70442907
	70442500
БУЛГАН	70342399
	70342935
ГОВЬ-АЛТАЙ	70483500
	70483430
ГОВЬСҮМБЭР	02542-40647
ДАРХАН-УУЛ	70377940
	70374513
	70373730
ДОРНОГОВЬ	70523200
	70523000
ДОРНОД	70584642
	70583079
	70583069
ДУНДГОВЬ	70592204
	70593602
	70592415
ЗАВХАН	70463000
	70463815

ОРХОН	70359299
ӨВӨРХАНГАЙ	70323259
	01322-23499
ӨМНӨГОВЬ	70533320
	70533466
	70532242
СҮХБААТАР	70518452
	70518675
СЭЛЭНГЭ	70363692
	70362385
ТӨВ	70272222
	70272138
УВС	70452343
	70452342
	70452507
ХОВД	70433470
	70433731
	70433951
ХӨВСГӨЛ	70382222
	70384846
ХЭНТИЙ	70382611
	70562514
ЗАМЫН-ҮҮД	70527474
	70527878



МОНГОЛ
ШУУДАН

MyDelivery 




**ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ
ОНЛАЙНААР АВДАГ БОЛЛОО**






Тэмдэглэл

A series of horizontal dotted lines for writing, spanning the width of the page.



МОНГОЛ
ШУУДАН

Өдөр бүр уулзах үндэсний
шилдэг компани

 TheMongolPost
 Монгол шуудан /Mongol shuudan/
 www.mongolpost.mn

“МОНГОЛ ШУУДАН” ХК

Сүхбаатарын талбай-9, ЧД, I хороо, Энхтайвны өргөн чөлөө, Ш/Х-1106,
Улаанбаатар-15160, Монгол улс

+(976) 1800-1613

info@mongolpost.mn

